



**МОНГОЛ УЛСЫН
ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД**


Засгийн газрын XII байр, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 31 06 12, 7600 3333-1126, Факс: (976-11) 32 29 04,
Цахим шуудан: info@mudch.gov.mn,
Цахим хуудас: www.mudch.gov.mn

2025.12.01 № 01/4417
танай _____-ны № _____-т

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
О.САРАНЧУЛУУН ТАНАА**

Таны 2025 оны 49 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу холбогдох мэдээ, мэдээллийг эрхлэх асуудлынхаа хүрээнд гаргаж, Хот байгуулалт, хотын стандартын газраас авч хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт хуудастай



Э.БАТ-АМГАЛАН

1525040540

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын
2025 оны 12 дүгээр сарын 01 өдрийн 01/4477
дугаартай албан бичгийн хавсралт

- 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын Конвенцын 9 зүйл. Хүртээмж; Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйл. Орон сууц, дэд бүтцийн байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэхээр заасныг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар:**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 9.3-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй буюу түүний хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжийн орчны болон дотоод зохион байгуулалтын заавал дагаж мөрдөх үндэсний стандартыг барилгын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.”; 25.2-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг халамжийн, түрээсийн, ипотекийн зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулах орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний болон аймаг, нийслэлийн Засаг даргын жил бүрийн төсөвт тусгана.” гэж тус тус заасан.

Түүнчлэн 2020 оны шинэчилсэн найруулгаар баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.3.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор холбогдох хөтөлбөрүүдийг хүчингүй болсонд тооцсон бөгөөд дэд хөтөлбөр батлан хэрэгжүүлэх эрх зүйн орчныг хязгаарласан.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах нийслэлийн салбар зөвлөл”-ийн 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 3 дугаар улирлын хэрэгжилтийн тайланг хүргүүлэв.

- 2. Танай яамнаас хэрэгжүүлж байгаа орон сууцжуулалт болон түүнтэй холбоотой төсөл, хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хэрхэн хамруулж байгаа болон хөнгөлөлттэй орон сууцны хөтөлбөрт хамруулах, орон сууцжуулах талаар баримталж байгаа бодлого, арга хэмжээ:**

Тус яамны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн хүрээнд иргэдийг орон сууцжуулалтыг хөгжүүлэх, орон сууцны бодлого, төлөвлөлт, төсөл, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулалтаар хангах арга зорилтын хүрээнд Барилга, хот байгуулалтын сайдын (хуучнаар) 2017 оны 26 тоот тушаалаар “Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцад хамруулах журам”-ын дагуу төрийн түрээсийн орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллаж байна.

- 3. Сүүлийн гурван жилд орон сууцжуулах хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хэрхэн хамруулсан талаарх тоон мэдээлэл тайланг ирүүлнэ үү.**

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоолоор “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2016 оны 38, 169, 298 дугаар тогтоолуудаар “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-д 1,521, “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-д 972 айлын орон сууцыг төрийн түрээсийн орон сууцны санд тус тус шилжүүлж, Барилга, хот байгуулалтын сайдын (хуучнаар) 2017 оны 26 тоот тушаалаар “Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцад хамруулах журам”-ын 2.2-т залуу хөгжлийн бэрхшээлтэй

иргэдийн квотыг Улаанбаатар хотод 5, орон нутагт 5 хувь байхаар тус тус тогтоон хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Дээрх төрийн түрээсийн орон сууцны сангийн 5.7 хувь буюу нийт 141 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулсан бөгөөд үүний 109 нь Улаанбаатар хотод, 32 нь хөдөө орон нутагт тус тус хамрагдсан байна.

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-д шилжүүлсэн 1,521 айлын төрийн түрээсийн орон сууцны 6.1 хувь буюу 93 айлын орон сууцыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулснаас 61 нь Улаанбаатар хотод, 32 нь хөдөө орон нутагт, “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-д шилжүүлсэн 972 айлын төрийн түрээсийн орон сууцны 4.9% буюу 48 айлын орон сууцыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тус тус хамруулсан.

Хүснэгт: “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-д шилжүүлсэн төрийн түрээсийн орон сууцанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулсан байдал

№	Аймаг, Нийслэл	Орон сууцны нийт тоо	ХБИргэдийн тоо	ХБИргэдийн квот	Эзлэх хувь
1	Буянт-Ухаа 2	565	41	5%	7.2%
2	Хангай хотхон	223	17	5%	7.6%
Нийслэл дүн		788	61		7.4%
3	Сэлэнгэ Мандал сум	102	2	5%	1.9%
4	Дархан	152	7	5%	4.6%
5	Хэнтий	140	4	5%	2.9%
6	Увс	105	4	5%	3.8%
7	Ховд	114	6	5%	5.3%
8	Архангай	120	9	5%	7.5%
Орон нутаг дүн		733	32		4.3%
Нийт дүн		1,521	93		6.1%

Эх үүсвэр: “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ

**“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ НИЙСЛЭЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ”-ИЙН
2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 3 ДУГААР УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТ**
(Хот байгуулалт, хотын стандартын газар)

2025 оны 09 дүгээр сарын 04

Улаанбаатар хот

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин		Хэрэгжилт	Хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин		
1	2	3	4	5	6	7
1	Явган хүний зам, талбайн төлөвлөлт, техникийн шаардлага /MNS 6808:2019/ стандартыг хангах, сайжруулах, хяналт тавих;	Хэрэгжилтийн хувь	-	100	1. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/237 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны А/31 дүгээр тушаалын дагуу хууль, тогтоомж, стандартын хэрэгжилт, орчны аюулгүй байдлыг хангуулахаар 9 дүүрэгт хийгдэж байгаа явган хүний зам, талбайн тохижилтын ажилд НИТХ-ын 2023 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй дэд бүтэц” бүлэгт хамаарах хотын стандартын зөвлөмж хуудсыг 9 дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 01/301 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Багахангай дүүргийн Хангай цогцолбор сургуулийн налуу замыг шинэчлэх ажилд зөвлөмж өгч, хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжтэй байдлыг хангаж ажиллав. 2. 2025 онд нийслэлийн хэмжээнд төсвийн хөрөнгөөр хэрэгжих тохижилт бүтээн байгуулалтын ажлыг хотын стандартын шаардлагад нийцүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжтэй байдлыг хангуулах ажлын хүрээнд Зөвлөн туслах арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. 3. Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссын зөвлөмжийн биелэлт, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй дэд бүтэц бүлгийн хотын стандартуудыг мөрдүүлэх, арга хэмжээний саналыг бэлтгэн 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр хүргүүлэв. 4. Батлагдсан хотын стандартыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах чиглэлээр зурагт постер бэлтгэн “Улаанбаатар мэдээ” таниулах хуудсанд 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдөр нийтэлсэн.	75
2	Барилга, байгууламжийн	Хэрэгжилтийн хувь	100	100	Нийслэлийн Хяналт шалгалтын газрын даргын 2025 оны А/47 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургууль,	75

1	2	3	4	5	6	7
	саадгүй байдал, хүртээмжийн байдалд үнэлгээ хийх, холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийн тайланд дүгнэлт хийх;				цэцэрлэгийн барилга байгууламж, гадна орчны стандартын хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай" удирдамжийн хүрээнд нийслэлийн 9-н дүүргийн хэмжээнд 180 сургууль, цэцэрлэгт урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийсэн. Тус ажлын хүрээнд UCS 1101B:2022 "Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага", UCS 1102B:2022 "Ерөнхий боловсролын сургуулийн гадна орчинд тавих ерөнхий шаардлага" хотын стандартын дагуу гадна орчны чиглэлийн 17 үзүүлэлтээр шалгах хуудас бөглөн, гадна орчин, шат довжоог хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй, стандартад нийцүүлэх 180 зөвлөмжийн хуудсыг цэцэрлэг, сургуульд хүргүүлсэн.	
3	Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин, үндсэн шаардлага /MNS 6055:2009/ хэрэгжилтийг хангуулах, хяналт, шалгалтыг тогтмолжуулах;	Хэрэгжилтийн хувь	100	100	UCS 1001A:2023 Хөгжлийн бэрхшээлтэй хүнд дэд бүтцийн хүртээмжийг дээшлүүлэх арга зүйн удирдамж, Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй дэд бүтэц энэхүү хотын стандарт нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 42 дугаар тогтоолоор батлагдаж, 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс Улаанбаатар хотод хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Тус стандартад: - Нийтийн бие засах хэсгийн нэг өрөө (кабин)-г тулгуур, таяг болон бусад тоног, хэрэгсэл ашигладаг хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулж хажуугийн хана дагуулсан бариул, хувцасны өлгүүр, бусад хамрагдах тоноглолын хамт тохижуулж; - Барилгад тэргэнцэртэй иргэн хэн нэгний тусламжгүйгээр нэвтрэх боломжийг хангаж, шалны хоорондох уналтын зөрүү 4 см-ээс их бол налуу зам хийх ба 1х12 харьцаатай байна гэж тус тус заасан байдаг.	85
4	Шинээр барилга барихад зураг төслийн стандартыг мөрдүүлэн ажиллах;	Хэрэгжилтийн хувь	100	100	2025 оны 3 дугаар улирлын байдлаар нийт барилга, байгууламжийн 857 Архитектур төлөвлөлтийн даалгавар, 582 Загвар зурагт хөгжлийн бэрхшээлтэй иргэний налуу зам /рамп/-ын төлөвлөлтийг тусгуулан баталсан. 1. Төрийн байгууллагын гадна орчны хүртээмжтэй байдлын тухай хороо, өрхийн эмнэлгийн цогцолбор барилгуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлын судалгаагаар дараах	85


1	2	3	4	5	6	7
					үр дүнг тодорхойлсон. /2021/ Судалгаанд 161 хороо хамрагдсан. Үүнээс: ✓ Стандартын шаардлага хангасан 48 хороо /70%/ ✓ Стандартын шаардлага хангахгүй 131 хороо /30%, (Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан налуу замгүй, налуу замтай ч хэт налуу, хөтөч хавтан, анхааруулах хавтангүй, бариул үсэг нь тэмдэглээгүй, шат бариул стандарт бус байсан) 2. Төрийн байгууллагын барилгуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлын судалгааг 9 Дүүргийн ЗДТГ-аас авч, үр дүнг "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах нийслэлийн салбар зөвлөл"-ийн дараагийн хуралдаанд танилцуулахаар ажиллаж байна.	

4 арга хэмжээний хэрэгжилтийн хувь- 80 %

ХЯНАСАН: ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

НЭГТГЭСЭН: МЭРГЭЖИЛТЭН

 Д.ДАШЦЭЦЭГ

 Т.АРМАН